

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
Биеийн Тамир Спортын Газрын
Даргын Тушаал

2020 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/02

Сүмбэр сум

Албан хаагч, ажилчдын "Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр", "Сургалтын хөтөлбөр", 2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 17, 18 дугаар бүлэг, төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь :

1. Байгууллагын албан хаагч, ажилчдын "Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-г 1 хавсралтаар, "Төрийн албан хаагч, ажилчдын Сургалтын хөтөлбөр"-г 2 дугаар хавсралтаар, Албан хаагч, ажилчдын 2020 онд хэрэгжүүлэх "Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө"-г 3 дугаар хавсралтаар, Албан хаагч, ажилчдын 2020 онд хэрэгжүүлэх "Сургалтын төлөвлөгөө"-г 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Цаашид хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн тайлагнахыг Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах албаны дарга /М.Батдэлгэр/-т даалгасугай

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийг төсөвт жил бүр тусгаж байхыг ня-бо /Б.Лүнгэрэгжанцан/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.БУЯНТОГТОХ

:\Documents and Settings\ tushaal

1422010002

Биеийн тамир, спортын газрын даргын
2020 оны 01 дугаар сарын 03 өдрийн
А/02 тоот тушаалын 2 хавсралт

УСАНДЭМЖ 1010073

Биеийн тамир, спортын газрын албан хаагчийн

сургалтын хөтөлбөр

Нэг: Нийтлэг үндэслэл

Говьсүмбэр аймгийн Биеийн тамир, спортын газар нь орон тооны 18 албан хаагч, ажилчидтай үйл ажиллагаагаа явуулж байна. Төрийн захиргааны албан хаагч-3, төрийн үйлчилгээний албан хаагч 15 байна. Боловсролын түвшингээр дээд боловсролтой 11, бүрэн дунд боловсролтой- 7 албан хаагчид байна.

Биеийн тамир, спортын чиглэрээр ажиллаж буй мэргэжилтэн, үйлчилгээний ажилтан, албан хаагчдад мэргэжлийн өндөр ур чадвартай, төрийн ёс зүйг чандлан баримтладаг, мэргэжлийн болон хууль эрх зүйн мэдлэг боловсролоо тогтмол дээшүүлэх эрмэлзлэл бүх байх шаардлага тавигдаж байна. Иймд төрийн албан хаагч нь төрийн албаны шинэчлэлийг хэрэгжүүлэгч гол нөөц болсон мэдлэг, ур чадвараа байнга дээшүүлж байх шаардлагатай ба төрийн албан хаагчийн үр нөлөө, үр ашигтай ажиллах нөхцөл, баталгаа нь түүнийг хөгжүүлэх, төрийн албаны болон мэргэжлийн сургалтанд хамруулан чадавхийг нь тасралтгүй дээшүүлэх явдал юм.

Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл нь төрийн захиргааны зорилт, чиг үүргийг мэдлэг чадвартай, мэргэшсэн төрийн албан хаагчдын хүчээр хэрэгжүүлж, иргэдэд сайн, төрийн үйлчилгээ үзүүлэх шаардлага, хариуцлагын шинэ тогтолцоог бий болгов.

Төрийн захиргаа, төрийн албаны шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлэх гол нөөц нь мэдлэг чадвараа дээшлүүлж байх хэрэгцээг шаардаж байна.

Төрийн албан хаагчийн үр нөлөө, үр ашигтай ажиллах нэгэн нөхцөл, баталгаа нь түүнийг хөгжүүлэх, төрийн албаны сургалтад хамруулан чадавхийг нь тасралтгүй дээшлүүлэх явдал юм.

Биеийн тамир, спортын газрын нь Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын яамны сайдын 2016 оны А/149 дугаар тушаалын "Биеийн тамир спортын салбарын хүний нөөцийн хөтөлбөр, Засгийн газрын эрхлэх газрын дарга, Төрийн албаны салбар зөвлөлийн хамтарсан 2019 оны 37/33 дугаар тушаалын мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр"-ийг үндэслэн боловсруулсан болно.

Хөтөлбөрийн зорилго

Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчдад засгийн газрын 2019 оны 153 дугаар тогтоол "Биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого болон байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төрийн үйлчилгээг иргэдийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүргэхэд шаардагдах мэдлэг чадварыг бий болгох, суралцагч байгууллага болоход оршино.

Хөтөлбөрийн зорилт

1.3.1. Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх замаар байгууллагын хөгжлийг хангах, байгууллагын зорилтыг хэрэгжүүлэхэд нөөцийг ашиглах, төрийн захиргааны болон төрийн шинэтгэлийн бодлогыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

1.3.2. Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах.

3-1.3.3. Төрийн албан хаагч нь эрхэлсэн ажил, албан үүргээ амжилттай гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, мэдээлэл, олж авах, онол арга зүй, ур чадвар эзэмших.

Хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга зам

1.4.1. Үйл ажиллагааны чадавхи сайтай байгууллага байх.

1.4.2. Мэдлэг, чадвартай төрийн захиргааны мэргэшсэн албан хаагчидтай болсон байх.

1.4.3. Биеийн тамир, спортын газар нь суралцагч байгууллага болсон байх.

1.4.4. Төрийн албан хаагчдын манлайлал ба оролцооны өндөр түвшинг хангах.

1.4.5 Албан хаагч, ажилчдын мэдлэг, чадварыг олгох явцыг нээлттэй, ил тод байдлаар хэрэгжүүлнэ.

1.4.7 Албан хаагчдын манлайлал ба оролцооны түвшинг хангах, мэдлэг чадвар бий болгох явц нь төрийн албан хаагчаас сургалтанд оролцох, хувийн санаачлага гаргах зэрэг боломжийг ханган ажиллана.

1.5.Хөтөлбөрийн санхүүжилт, хугацаа

1.5.1. Биеийн тамир, спортын газар нь төрийн албан хаагчдын сургалтад зориулсан санхүүжилтийг жил бүр төсөвтөө тусган шийдвэрлэнэ.

1.5.2. Төрийн албан хаагчдын өөрсдийнх нь хандив, төсвийн нэмэлт нөөц бололцоо, бусад эх үүсвэрийг ашиглан хөтөлбөрийн санхүүжилтэнд зарцуулна.

1.5.3. Хөтөлбөрийн 2020-2024 онд хэрэгжүүлнэ.

Хоёр: Бодлого

2.1. Үндсэн зарчим ба үнэт зүйлс:Төрийн албан хаагч нь Биеийн тамир, спортын газрын хамгийн чухал нөөц мөн. Иймд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг бий болгох аливаа арга хэмжээг хөрөнгө оруулалт гэж үзнэ. Сургалтын хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход дор дурдсан үндсэн зарчим ба үнэт зүйлсийг баримтлана.

2.1.1. Ардчилалыг бэхжүүлэх: Төрийн албан хаагчдыг сургаж өөрийн байгууллагад мэдлэг чадвар бий болгох нь төрийн албаны ардчилалын үнэт зүйлсийг бэхжүүлнэ. Иймд мэдлэг чадвар бий болгох явцыг түүнд оролцох, хувийн санаачлага гаргах, өргөн боломжийг хангасан ардчилсан замаар хөгжүүлнэ.

2.1.2. Зах зээлийн эдийн засгийн орчны өөрчлөлтийг харгалзан мэдлэг чадварыг бий болгохдоо зах зээлийн эдийн засгийн өөрчлөлтийг харгалзан үзнэ. Биеийн тамир, спортын газрын хэмжээнд мэдлэг чадвар бий болгох үйл явцад дотоодын бололцоотой бүх нөөцийг ашиглана.

2.1.3. Үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх: Мэдлэг чадвар бий болгох нь Биеийн тамир, спортын газрын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэр хязгаарлагдмал тул сургалтын болон мэдлэг чадвар бий болгох үйл явцыг өртөг зардал хямдтайгаар хэрэгжүүлэхийг чухалчилна.

2.1.4. Ил тод байдал, хариуцлагын тогтолцоог эрхлэх:Биеийн тамир, спортын газрын хэмжээнд мэдлэг, чадвар бий болгох үйл явцыг нээлттэй, ил тод байдлаар хэрэгжүүлнэ. Мэдлэг чадвар бий болгох бүх үйл ажиллагаа нь тодорхой заагласан үүрэг хариуцлагын тогтолцоотой байна.

2.1.5. Адил тэгш бололцоогоор хангах: Яс үндэс, нийгмийн гарал, хэл, арьс өнгө, нас хүйс, албан ажил болон үзэл бодлоор ялгаварлан гадуурхахгүйгээр сургалтад хамрагдах боломжийг хүн бүрт олгоно.

2.1.6. Үүрэг, хариуцлага хүлээх: Биеийн тамир, спортын газрын Ерөнхий менежер, удирдлагууд нь төрийн албан хаагчдыг сургах, давтан сургахад санаачилга гаргах, чадавхи бий болгох санаачлагыг урамшуулан дэмжих үүрэг хүлээнэ. Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчид өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, хамт олны бусад гишүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж багаар хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

2.2. Сургалтын талаар баримтлах бодлого:Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчийн сургалт нь ажилтнуудын болон удирдлагын мэдлэг чадвар, манлайлалыг дээшлүүлэх, удирдах чадавхийг бэхжүүлэх зорилго бүхий зохион байгуулалттай үйл ажиллагаа юм.

2.2.1.Биеийн тамир, спортын газрын хэмжээнд явагдах сургалт нь оролцогчид болон байгууллагын хэрэгцээнд түлгүүрласан зорилготой байна. Үүнд:

- Шинээр ажилд орсон хүмүүст танилцуулах сургалт
- Хувь хүний ур чадварыг дээшлүүлэх сургалт
- Мэдлэг хуваалцах сургалт
- Давтан сургалт

2.2.2. Түвшин: Засгийн газрын хэрэг эрхлэх газраас баталсан мэргэшүүлэх сургалт, давтан сургах сургалт, мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдах яамд болон бусад газрын сургалт, орон нутгийн чанартай төвлөрсөн бүсийн сургалт, дотоод нөөцөө ашиглан явуулах ажлын байран дээрх сургалт байна.

2.2.3. Багшлах нөөц: Бүх боломжтой багшлах нөөцийг сургалтад ашиглана. Ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулахад Удирдлагын акедами төгсөгчид болон мэргэжлийн чиглэлийн сургалтад хамрагдсан албан хаагчдын хүчийг ашиглана.

2.2.4. Суралцах боломжийг харгалзах: Ажиллахын зэрэгцээ суралцах хувилбараар зохион байгуулна.

2.2.5. Сургалтын хэлбэр: Ажлын байран дээрх сургалтад хамрагдагсдын оролцоо, суралцах идэвхийг нэмэгдүүлэх үүднээс олон хэлбэрийн заах аргыг хэрэглэнэ. Тухайлбал: Багаар ажиллах, жишээн дээр суралцах, дадлага хийх болон лекц, ярилцлага, бие дааж сурах

2.3. Мэдлэг чадвар бий болгох арга замын талаар баримтлах бодлого: Биеийн тамир, спортын газрын хэмжээнд мэдлэг, чадварыг бий болгоход төрөл бүрийн өргөн хүрээтэй дадлага, олон янзын арга замыг чухалчилж, төрийн албан хаагчдад мэдлэг, чадварыг өдөр тутмын ажлын явцад болон зохион байгуулалттай сургалтын хэлбэрээр бий болгоно.

Сургалтыг дараах хэлбэрээр зохион байгуулна.

1. Дотоодын сургалт
2. Гадаадын сургалт
3. Ажлын байран дах сургалт

2.4. Ажил дээр мэдлэг чадвар бий болгох талаар баримтлах бодлого:

Биеийн тамир, спортын газрын хэмжээнд суралцагч орчинг бүрдүүлснээр сууралцах нь төрийн албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг болно.

Суралцахад шаардлагатай цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан үзнэ.

Төрийн албан хаагчид өөр хоорондоо мэдлэг, мэдээллээ солилцох, түүнчлэн шинэ санаа, шийдэлд хүрэхэд шаардагдах цаг хугацааг үүнд хамруулна.

Байгууллагын дотор суралцах нь хувь хүн, бүлэг, байгууллагыг хөгжүүлдэг тул дараах оролцооны аргыг хөгжүүлнэ.

2.4.1. Багаар ажиллах: Мэдлэг мэдээллээ хуваалцахыг ажлын хэвшмэл хэсэг болгох.

2.4.2. Өдөр тутмын уулзалт: 2.2-оороо гэсэн зарчмаар ажиллаж, тулгарсан асуудалд хариу өгч, шийдэлд хүрэх замаар суралцах.

2.4.3. Шийдвэрлэх асуудалд тулгуурлан суралцах: Ажилтнуудад мэдээлэл хайж олж авах, түүнийгээ хуваалцах, туршилт хийж, шийдэлд хүрэх ба төгсгөлд нь шинээр олсон зүйлийнхээ талаар бусдад мэдээллэх.

2.4.4. Шавилан суралцах: Илүү туршлагатай ажилтан нь туршлага багатай нэгэндээ туслалцаа үзүүлэх

2.4.5. Суралцагчийн хөтөлбөр: Туршлагатай болох боломж олгохын тулд залуу ажилтнуудыг тухайн байгууллагын бүтцийн нэгжийн шаардлагатай ажлын байруудад ажиллуулж, ажиглалт хийлгэх

2.4.6. Ажил сэлгүүцэн ажиллуулах: Мэдлэг чадвар бий болгох зорилгоор ажлын арга барилаас харилцан суралцах, дадлага эзэмшүүлэхээр албан хаагчдыг газар, хэлтэс дээр сэлгэн ажиллуулах.

Гурав: Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Төрийн захиргаа албан хаагч болон багш, дасгалжуулагч, арга зүйчдэд сургалт явуулахдаа сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, сургалт явуулах, сургалтын үнэлгээ зэрэг хүчин зүйлүүдийг зөв зохистой төлөвлөн биелэлтийг хангаж, төрийн захиргааны албаны сургалтын агуулгад онол практикийн оновчтой хослолыг бий болгоход чиглүүлж ажиллана.

3.1. Удирдлагын акедамид мэргэшүүлэх багц, захилагын дагуу зохион байгуулах сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан сургалтад төрийн захиргааны албан хаагчдыг хамруулах.

3.2. Мэдлэг туршлагатай багш, дасгалжуулагч, ажилтныг дагалдуулан сургах, өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөртэй ажиллуулах, ажил, албан тушаал сэлгэн ажиллуулах зэргээр ажлын байранд нь сургах сургалтыг жил бүр төлөвлөн хэрэгжүүлнэ.

3.3. Төрийн захиргааны албан хаагчийг шинээр ажилд авахад болон албан тушаалын ангилал, зэрэглэл ахих, өөр ажилд шилжихэд тухайн шинэ орчин нөхцөлд шаардагдах мэдлэг, арга барил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлнэ. Зорилтот богино хугацааны сургалтыг холбогдох байгууллагад захиалах буюу өөрийн байгууллагын багшлах боловсон хүчнийг түшиглэн зохион байгуулна.

3.4. Төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр ажлын байран дээрх сургалтыг улирлаар нь төлөвлөн хэрэгжүүлнэ.

3.5. Төрийн албан хаагчдыг мэргэжлийг нь дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах сургалтын төлөвлөгөөг жил бүр төлөвлөгөөг жил бүр төлөвлөн хэрэгжүүлнэ.

3.6. Сургалт явуулах орчинг бүрдүүлж видеопроектор, персонал компьютер, дэлгэц, бусад техник хэрэгсэлтэй болох

Дөрөв: Үр дүн

4.1. Биеийн тамир, спортын газрын байгууллагын сургалтын хэрэгцээг байгууллагын удирдлага, ажилтан нар хамтран тодорхойлж болно. ажилтан өөрөө өөрийнхөө сургалтын хэрэгцээг тодорхойлж болно.

4.2. Сургалтын агуулгыг байгууллагын болон суралцагчийн хэрэгцээнд тулгуурлан боловсруулдаг арга зүйд шилжинэ.

4.3. Хувь хүний мэдлэг чадвар, туршлагыг байгууллагын мэдлэг чадвар, туршлага болон хөгжүүлэх бөгөөд ингэснээр суралцагч байгууллага болно.

4.4. Шинэ мэдлэг, туршлага бий болгосноор сайн үйл ажиллагаатай байгууллагыг төлөвшүүлэн иргэдийн бие бялдрын чийрэгжүүлэх, бэхжүүлэх эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн чанартай сайтай төрийн үйлчилгээ үзүүлэх

4.5. Байгууллагын дотоод нөөцийг ашиглаж, ажлын байран дах сургалтыг хөгжүүлнэ.

4.6. Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлж, тэднийг сургаж хөгжүүлснээр байгууллагын зорилго зорилт биелэнэ, Төрийн захиргааны шинэтгэлийг эрчимжүүлэх, Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулна.

4.7. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилгоор жил бүр сургалтын төлөвлөгөө болосвруулан хэрэгжүүлэх ба ингэснээр байгууллага суралцагч байгууллага болгон хөгжүүлнэ.


Хөтөлбөрийн боловсруулсан:

Мэргэжилтэн



М.Батдэлгэр

Биеийн тамир, спортын газрын даргын
2020 оны 01 дугаар сарын 05 өдрийн
А/02 тоот тушаалын 4 хавсралт



**Биеийн тамир, спортын газрын албан хаагчид, ажилчидын дунд
2020 онд зохион байгуулах сургалт хийх хуваарь**

2020.01.02

№	Сургалтын сэдэв	Хугацаа	Санхүүжүүлэх эх үүсвэр	Зохион байгуулах албан хаагчид
1	Дотоод эрх зүйн сургалтыг зохион байгуулах.	Сар бүр	Байгууллагын төсөв	Дотоод сургалт хариуцсан ажилтан болон, мэргэжилтэнүүд
2	Мэргэжилтнүүдийг гадаад, дотоод сургалтанд хамруулах	Жилдээ	Улс болон, орон нутгийн төсөв Байгууллагын төсөв	Мэргэжилтэн
3	Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамнаас зохион байгуулж буй сургалтанд мэргэжилтэн, багш дасгалжуулагч нарыг хамруулах	Жилдээ	Яамны төсөв Байгууллагын төсөв	Мэргэжилтнүүд
4	Спортын холбоодуудын удирдах ажилтны сургалт зохион байгуулах	1-р улиралд	Байгууллагын төсөв	Биеийн тамир, спортын мэргэжилтэн
5	Хүн амын бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах аргачлал, сургалтанд хамрандах	2,4-р улиралд	Байгууллагын төсөв	БСШУСЯ, спорт бэлтгэлийн төв
6	Санхүүгийн ажилтныг сургалтанд хамруулах	Удирдамж аар	Орон нутгийн төсөв Байгууллагын төсөв	Төрийн сангийн хэлтэс
7	Нярав, бичиг хэргийн ажилтаныг сургалтанд хамруулах	Жилдээ	Орон нутгийн төсөв Байгууллагын төсөв	АЗДТГазар
8	Монгол үндэсний олимпийн хорооноос зохион байгуулж буй сургалтанд хамруулах	Жилдээ	Байгууллагын төсөв	МҮОХороо
9	Бусад холбогдох цаг үеийн сургалтанд мэргэжилтнүүд, багш дасгалжуулагч нарыг хамруулах	Жилдээ	Улс болон, орон нутгийн төсөв Байгууллагын төсөв	Мэргэжилтэн, багш дасгалжуулагч нар

Төлөвлөгөө гаргасан:

Мэргэжилтэн

Б.Баярмаа